



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 25 өдөр

Дугаар А/335

Улаанбаатар хот

Шуурхай штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, 2022 оны 223 дугаар тогтоол, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны А/651, А/983 дугаар хамтарсан тушаал, захирамж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1084, А/1276 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн айл өрхүүдийн хэрэгцээнд бүх төрлийн хийн болон хагас коксон түлшийг нэвтрүүлэхтэй холбогдуулан айл өрхийн хэрэглээнд зааварчилгаа өгөх, байнгын хяналт тавих, түлшний нөөцийн тасралтгүй байдлыг хангах, иргэдийг угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, эрсдэлээс хамгаалах чиглэлээр зөвлөмж өгөх, хориглосон бусад хатуу түлшний хэрэглээнд хяналт шалгалт хийх, иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх, судалгаа, тайлан мэдээ гаргах, Нийслэлээс байгуулагдсан ажлын хэсгийг өдөр тутмын мэдээ мэдээллээр хангах, ажлын явцын тайланг холбогдох байгууллагад тогтмол хүргүүлж тайлагнаж ажиллах зорилго бүхий шуурхай штабыг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан шуурхай штабын үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

3. Халаалтын улиралд буюу 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд шуурхай штабын бүрэлдэхүүнийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, ажлын үр дүн, тайлан, мэдээ мэдээллийг тухай бүр танилцуулж ажиллахыг Засаг даргын орлогч бөгөөд Шуурхай штабын дарга (З.Бямбажав)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525011003